



АВСТРАЛИ УЛСЫН КҮЙНСЛАНД МУЖИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ (Иргэний эрх зүйн маргаан¹)

ХАРИУЦАГЧ ШҮҮХ ХУРАЛДААН ТОВЛОГДОХООС ӨМНӨ НОТЛОХ БАРИМТЫГ ГАРГААГҮЙГЭЭС ҮҮДЭН НЭХЭМЖЛЭГЧИД ГАРСАН ЗАРДЛЫГ² ХАРИУЦАГЧ ТӨЛӨХӨӨР ШИЙДВЭРЛЭЖЭЭ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн нэр: Mills v Footprints Community Limited (ABN 15 100 277 492) [2023] QDC 48

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Хариуцагч нь олон нийтэд түшиглэсэн тусламж дэмжлэгийн үйлчилгээ (community-based support services business) эрхэлдэг. Нэхэмжлэгч нь хариуцагчийг тус үйл ажиллагааг эрхлэхдээ гэмтлийн дараах стрессийн эмгэг (PTSD)-т өртсөний дараа үйлчлүүлэгчтэй хэрхэн харилцах, ялангуяа түрэмгий зан авир бүхий үйлчлүүлэгчтэй зүй зохистой харилцах тухай сургалт зэрэг ажилтнуудын өмнө хүлээх хэд хэдэн үүргийг зөрчсөн хэмээн маргаж, 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Хариуцагч нь ажилтнуудын сургалттай холбоотой хэрэгт ач холбогдол бүхий долоон шинэ баримтыг шүүх хурал болохын өмнө шүүхэд гаргаж өгсөн бөгөөд ирүүлсэн даруйд нэхэмжлэгчид танилцуулсан. Эдгээр шинэ баримттай холбоотойгоор шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагатай гэдэгтэй талууд маргаагүй боловч, 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр болох хувийн гэмтэлтэй³ холбоотой шүүх хурлыг хойшлуулах хүсэлтээс үүдэн гарах нэхэмжлэгчийн зардлын тухайд маргаан үүсгэжээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Нэхэмжлэгч шинээр ирсэн баримтуудтай богино хугацаанд танилцсан нь нэхэмжлэлийн агуулгыг тодруулах, баримт бичигт хариу өгөх зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж сөрөг нөлөө үзүүлсэн. Энэ талаар

¹ Эх сурвалж: https://archive.sclqld.org.au/qjudgment/2023/Judgment_Summary_2023_QDC_48.pdf

Хураангуйг орчуулахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.

Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://archive.sclqld.org.au/qjudgment/2023/QDC23-048.pdf>

² Шүүх хуралдаан хойшилсонтой холбоотой нэхэмжлэгчээс гарсан зардал гэдэгт шүүх хуралдаанд ирсэн унааны зардал болон нэхэмжлэл гаргахтай холбоотой бүхий л зардалыг ойлгоно.

³ Хувийн гэмтэл гэдэг нь бусад хүн болон байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас тухайн хүнд үүссэн бие махбодийн болон оюун санааны хохирлыг хэлнэ. (Кэмбрижийн толь <https://dictionary.cambridge.org/dictionary/english/personal-injury>)



талууд маргаагүй. Нэхэмжлэгчийн зүгээс баримтуудыг оройтуулан ирүүлсэн нь Ажилчдын нөхөн төлбөр авах, сэргээн засах эмчилгээ хийлгэх тухай хуулийн (Workers' Compensation and Rehabilitation Act 2003) 318С-д заасан "шүүх хуралдааныг үндэслэлгүй хойшлуулсан" гэх үндэслэлд хамаарна гэж үзэж, хариуцагч нь холбогдох зардлыг төлөх ёстой хэмээн мэдэгдсэн. Харин хариуцагчийн зүгээс баримт бичгийг олсон даруйд шүүхэд хүргүүлсэн нь үндэслэлгүйгээр шүүх хуралдааныг хойшлуулсан нөхцөл байдал биш хэмээн маргав.

Мөн хариуцагч талаас нэхэмжлэгчийг 2022 оны 09 дүгээр сард дивертикулитын⁴ улмаас хэвтэн эмчлүүлсэнтэй холбоотой мэдээллээ шинэчлэн 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр шүүхэд нотлох баримтаар гаргаж өгсөн бөгөөд энэхүү нотлох баримттай холбоотойгоор өөрт учирсан хохирлоо нэхэмжлэлдээ шинэчлэн тусгаагүй хэмээн марган энэхүү үйлдлийг хариуцагч "шүүх хуралдааныг үндэслэлгүй хойшлуулсан" гэх үндэслэлд хамаарна гэж үзсэн. Ийнхүү оролцогч талууд хоёул шүүх хуралдааныг үндэслэлгүй хойшлуулсан нь тогтоогдвол зардлын асуудлыг шийдвэрлэх боломжгүй хэмээн хариуцагч маргасан.

Шүүхээс хариуцагч тал нь мэдээллээ боломжит хугацаанд ил болгох үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон бөгөөд үүнээс шалтгаалан шүүх хурлыг хойшлуулах шаардлагатай болсон гэж дүгнэсэн. Мөн дээрх баримт бичгүүд хэрэг хянан шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой баримт бичгүүд байсан бөгөөд хэдийгээр хариуцагч нь баримтуудыг олсон даруйдаа ил болгосон ч үндэслэлгүй хойшлуулсан гэх нөхцөлийг үгүйсгэх үндэслэл тогтоогдсонгүй. Нэхэмжлэгчийн зүгээс эмнэлгийн бүртгэлийг шинэчлэн хүргүүлсэн баримтыг шүүхээс "чухал ач холбогдолтой" баримт гэж үзээгүй. Учир нь энэ баримт нь гэмтэлтэй холбоогүй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үзүүлэх нөлөө бага гэж үзэв.

Улмаар шүүхээс хариуцагч нь ач холбогдол бүхий баримтуудыг хожимдуулж ирүүлснээс шалтгаалан шүүх хуралдаан хойшилсон тул нэхэмжлэгчээс гарах зардлыг хариуцагч төлөх ёстой хэмээн шийдвэрлэсэн байна.

Орчуулсан: О.Төрболд
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн
Иргэний эрх зүйн судлаач

---o0o---

⁴ Бүдүүн гэдэсний цүлхэнт өвчин, https://erdemed.com/clinic/diverticular_disease/